



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2023.2.17 № 84
танай _____-ны № _____-т

ХОТЫН СТАНДАРТ ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА
С.ТӨМӨРДУЛАМ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус газрын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 18 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98,5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хотын стандарт хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2023/90/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-нийцлийн хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр Утас: 327734 Цахим хаяг: Munkhbayarz@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: Gantugss@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Н.Баттогоо Утас: 325093 Цахим хаяг: Battogoon@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Мөнхтуяа Утас: 325093 Цахим хаяг: Munkhtuyaja@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт.....	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
СЯ	Сангийн яам
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Сөвлөн төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54, -
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2023.2.17 № 02
танай _____ -ны № _____ -Т

ХОТЫН СТАНДАРТ ХЯНАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА
С.ТӨМӨРДУЛАМ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Хотын стандарт хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус газрын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

D:\audit\2023\Хотын стандарт хяналтын газрын 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан.docx

002021142

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 18 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98,5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

D:\Data\y2023\Audit\Audit\Gover\0021.02.15.HUD.Tsagda.docx

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>172,275,070.00</u>	<u>54,899,015.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,990,000.00	8,990,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,990,000.00	8,990,000.00
3121	Төгрөг	8,990,000.00	8,990,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	8,990,000.00	8,990,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	163,285,070.00	45,909,015.00
351	Түүхий эд материал	125,699,410.00	5,899,600.00
35110	Тусгай зориулалттай материал	125,699,410.00	5,899,600.00
354	Хангамжийн материал	37,585,660.00	40,009,415.00
35410	Бичиг хэргийн материал	4,568,250.00	839,325.00
35420	Аж ахуйн материал	10,422,790.00	4,928,190.00
35440	Түлш, шатах тослох материал	3,950,000.00	500,000.00
35470	Бусад хангамжийн материал	18,644,620.00	33,741,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>747,236,636.82</u>	<u>516,618,701.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	747,236,636.82	516,618,701.97
392	Биет хөрөнгө	278,969,058.74	144,434,380.05
39203	Авто-тээврийн хэрэгсэл	179,800,000.00	93,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-32,813,541.55	-29,218,749.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	152,228,332.00	139,292,905.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-56,401,469.83	-90,801,103.49
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,400,148.34	44,944,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,244,410.22	-13,282,771.56
393	Биет бус хөрөнгө	468,267,578.08	372,184,321.92
39301	Програм хангамж	1,430,000.00	1,430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,191,666.60	-1,430,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	564,860,834.00	564,860,834.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-96,831,589.32	-192,676,512.08
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>919,511,706.82</u>	<u>571,517,716.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>8,990,000.00</u>	<u>8,990,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,990,000.00	8,990,000.00
413	Өглөг	8,990,000.00	8,990,000.00
4136	Бусад өглөг	8,990,000.00	8,990,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	8,990,000.00	8,990,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>910,521,706.82</u>	<u>562,527,716.97</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	910,521,706.82	562,527,716.97
512	Хуримтлагдсан үр дүн	910,521,706.82	562,527,716.97
51210	Өмнөх үеийн үр дүн	1,100,769,295.62	910,521,706.82
51220	Тайлант үеийн үр дүн	(190,247,588.80)	-347,993,989.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>919,511,706.82</u>	<u>571,517,716.97</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	947,273,690.00	1,343,446,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	218,090.00	472,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	218,090.00	472,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	218,090.00	472,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	472,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,400.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	201,690.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	947,055,600.00	1,342,973,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	947,055,600.00	1,342,973,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	947,055,600.00	1,342,973,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,137,521,278.80	1,631,209,981.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,137,521,278.80	1,631,209,981.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	825,256,622.03	1,492,211,161.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	527,752,403.00	539,184,188.00
210101	Үндсэн цалин	377,701,377.19	384,440,427.00
210102	Нэмэгдэл	64,360,480.00	64,504,127.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,781,002.81	42,647,162.00
210104	Урамшуулал	39,909,543.00	47,592,472.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,203,689.87	67,682,725.00
210201	Тэтгэврийн даатгал	48,279,119.77	46,127,074.46
210202	Тэтгэмжийн даатгал	5,355,437.39	5,426,711.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,203,709.35	4,301,049.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1,033,221.54	1,075,262.59
210205	Эрүүл мэндийн даатгал	10,332,201.82	10,752,626.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,980,000.00	21,861,020.00
210304	Байрны түрээс	5,980,000.00	21,861,020.00
2104	Хангамж, бараа материалын зардал	63,675,520.36	157,993,973.59
210401	Бичиг хэрэг	48,766,040.00	136,436,535.00
210402	Тээвэр, шатахуун	7,810,000.00	9,530,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,164,914.36	6,760,268.59
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	670,116.00	557,000.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	4,710,120.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,430,800.00
210604	Урсгал засвар	00.00	1,430,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,882,370.00	533,670,728.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,000.00	532,555,242.00

Хотын стандарт хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	187,110.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	226,760.00	165,476.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	102,500.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,336,000.00	802,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,558,638.80	170,387,726.42
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	152,078,638.80	170,387,726.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	312,264,656.77	138,998,820.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,182,000.00	2,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,182,000.00	2,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	309,082,656.77	136,598,820.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	309,082,656.77	136,598,820.41
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	00.00	-287,763,781.42
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	60,230,208.43
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	60,230,208.43
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-190,247,588.80	-60,230,208.43
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-190,247,588.80	-347,993,989.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	947,072,000.00	1,343,446,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,400.00	472,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,400.00	472,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,400.00	472,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	472,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,400.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	947,055,600.00	1,342,973,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	947,055,600.00	1,342,973,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	947,055,600.00	1,342,973,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	947,072,000.00	1,343,446,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	947,072,000.00	1,343,446,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	634,807,343.23	1,204,447,379.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	527,752,403.00	539,184,188.00
210101	Үндсэн цалин	377,701,377.19	384,857,652.00
210102	Нэмэгдэл	65,112,738.00	65,579,798.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,015,499.81	41,086,537.00

Хотын стандарт хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210104	Урамшуулал	39,922,788.00	47,660,201.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,203,689.87	67,682,725.00
210201	Тэтгэврийн даатгал	48,279,119.77	46,127,074.46
210202	Тэтгэмжийн даатгал	5,355,437.39	5,426,711.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,203,709.35	4,301,049.33
210204	Ажилгүйдлийн даатгал	1,033,221.54	1,075,262.59
210205	Эрүүл мэндийн даатгал	10,332,201.82	10,752,626.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,980,000.00	21,861,020.00
210304	Байрны түрээс	5,980,000.00	21,861,020.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,154,960.36	16,013,118.59
210401	Бичиг хэрэг	5,220,000.00	2,368,725.00
210402	Тээвэр, шатахуун	8,500,000.00	6,080,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,164,914.36	6,760,268.59
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	999,696.00	804,075.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,953,920.00	1,680,800.00
210604	Урсгал засвар	00.00	1,680,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,282,370.00	558,025,528.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	556,910,042.00
210803	Даатгалын үйлчилгээ	187,110.00	98,010.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	226,760.00	165,476.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	102,500.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,766,000.00	802,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	312,264,656.77	138,998,820.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,182,000.00	2,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,182,000.00	2,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	309,082,656.77	136,598,820.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	309,082,656.77	136,598,820.41
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	2,125,635.00	
22	Хөрөнгийн зардал	2,125,635.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	2,125,635.00	
223001	Бусад хөрөнгө	2,125,635.00	
6	Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(2,125,635.00)	
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(2,125,635.00)	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,115,635.00	8,990,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,990,000.00	8,990,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	1,100,769,295.62	1,100,769,295.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	1,100,769,295.62	1,100,769,295.62
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-190,247,588.80	-190,247,588.80
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	910,521,706.82	910,521,706.82
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	910,521,706.82	910,521,706.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	910,521,706.82	910,521,706.82
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-347,993,989.85	-347,993,989.85
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	562,527,716.97	562,527,716.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	/төгрөгөөр/			
	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,342,973,700.00	1,206,847,379.59	136,126,320.41	89.9
УРСГАЛ ЗАРДАЛ	1,342,973,700.00	1,206,847,379.59	136,126,320.41	89.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,301,872,300.00	1,204,447,379.59	97,424,920.41	92.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	596,128,200.00	539,184,188.00	56,944,012.00	90.4
Үндсэн цалин	371,896,600.00	384,857,652.00	-12,961,052.00	103.5
Нэмэгдэл	75,427,400.00	65,579,798.00	9,847,602.00	86.9
Унаа хоолны хөнгөлөлт	72,600,000.00	41,086,537.00	31,513,463.00	56.6
Урамшуулал	76,204,200.00	47,660,201.00	28,543,999.00	62.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,167,600.00	67,682,725.00	11,484,875.00	85.5

Хотын стандарт хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тэтгэврийн даатгал	36,244,200.00	46,127,074.46	-9,882,874.46	127.3
Тэтгэмжийн даатгал	10,730,800.00	5,426,711.92	5,304,088.08	50.6
ҮОМШӨ-ний даатгал	8,584,700.00	4,301,049.33	4,283,650.67	50.1
Ажилгүйдлийн даатгал	2,146,200.00	1,075,262.59	1,070,937.41	50.1
Эрүүл мэндийн даатгал	21,461,700.00	10,752,626.70	10,709,073.30	50.1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,580,500.00	21,861,020.00	5,719,480.00	79.3
Байрны түрээс	27,580,500.00	21,861,020.00	5,719,480.00	79.3
Хангамж, бараа материалын зардал	24,756,100.00	16,013,118.59	8,742,981.41	64.7
Бичиг хэрэг	2,610,000.00	2,368,725.00	241,275.00	90.8
Тээвэр, шатахуун	6,546,100.00	6,080,050.00	466,050.00	92.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,960,000.00	6,760,268.59	7,199,731.41	48.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	804,075.00	195,925.00	80.4
Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,680,800.00	319,200.00	84.0
Урсгал засвар	2,000,000.00	1,680,800.00	319,200.00	84.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	572,239,900.00	558,025,528.00	14,214,372.00	97.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	570,000,000.00	556,910,042.00	13,089,958.00	97.7
Даатгалын үйлчилгээ	300,000.00	98,010.00	201,990.00	32.7
Тээврийн хэрэгслийн татвар	331,000.00	165,476.00	165,524.00	50.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	200,000.00	50,000.00	150,000.00	25.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,408,900.00	802,000.00	606,900.00	56.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41101400.00	2400000.00	38,701,400.00	5.8
Бусад урсгал шилжүүлэг	41,101,400.00	2,400,000.00	38,701,400.00	5.8
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	2,400,000.00	2,600,000.00	48.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,342,973,700.00	1,206,847,379.59	136,126,320.41	89.9
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,342,973,700.00	1,206,374,879.59	136,598,820.41	89.8
Орон нутгийн төсвөөс	1,342,973,700.00	1,206,374,879.59	136,598,820.41	89.8
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	472,500.00	-472,500.00	
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	472,500.00	-472,500.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	8,990,000.00	-8,990,000.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	8,990,000.00	-8,990,000.00	
АЖИЛЛАГСДЫН ТОО	59.00	43.00	16.00	72.9
Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	58.00	42.00	16.00	72.4

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Тус газар нь *“Нийслэлийн иргэд, оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зарчмын хүрээнд хотын стандартын тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэх.”* гэсэн зорилгын хүрээнд:

- *Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх,*
- *Хотын стандартыг боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих,*
- *Хотын стандартыг хэрэглэх, дагаж мөрдөхөд чиглэсэн удирдамж, арга зүйн тогтолцоог хөгжүүлэх,*
- *Хотын стандартын баримт бичгийн лавлагаа, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх,*
- *Хотын стандарт батлуулах талаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх, арга зүйгээр хангах, стандарт, норм, дүрмийг мөрдүүлэхэд төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг мэдээлэл, сургалт, арга зүйгээр хангах,*
- *Зөвлөн туслах, сурталчлан таниулах, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах” зорилтуудыг дэвшүүлэн ажилладаг байна.*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын, Төрийн албаны, Хөдөлмөрийн, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн, Татварын багц, Нийгмийн даатгалын тухай хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомжууд, МУЗГ болон Сангийн Яамнаас гаргасан заавар, журмуудыг хэрэгжүүлэн ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хотын стандарт хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан баталсан хэдий ч зарим зүйл заалт нь тодорхойгүй байна.

Тухайлбал: Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрийн гол үйл ажиллагаа болох хотын стандартын төсөл болон судалгааны ажлыг хэрхэн бүртгэх талаар тусгасан тодорхой заалтгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хотын стандарт хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 347,993.9 мянган төгрөгөөр буюу 37.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,990.0	8,990.0	-
Авлага	-	-	-
Бараа материал	163,285.0	45,909.0	(117,376.0)
Үндсэн хөрөнгө	747,236.6	516,618.7	(230,617.9)
Нийт хөрөнгө	919,511.7	571,517.7	(347,993.9)
Өр төлбөр	-	-	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	919,511.7	571,517.7	(347,993.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	919,511.7	571,517.7	(347,993.9)

Мөнгөн хөрөнгө дансны 8,990.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь “Монгол хьюндай автоматив” ХХК-д олгох барьцаа хөрөнгийн үлдэгдэл байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 163,285.0 мянган төгрөгөөс 45,909.0 мянган төгрөг болж 117,376.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд тус газар нь төсвийн хөрөнгөөр 113,282.6 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 4,710.0 мянган төгрөгийн бараа материал акталж, 225,948.6 мянган төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 516,618.7 мянган төгрөг болж 230,617.9 мянган төгрөгөөр буурсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 60,230.2 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй авто тээврийн хэрэгслийг “Нийслэлийн Төр захиргааны авто бааз” ОНӨТҮГ руу шилжүүлж, тайлант онд нийт 170,387.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулж ажилласан байна. Мөн НӨХГ-ын шийдвэрээр

элэгдлээрээ өртгөө нөхсөн 20,391.5 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 396,172.5 мянган төгрөгөөр буюу 41.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 396,374.2 мянган төгрөгөөр буюу 41.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал зэрэг зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 5,878,311.2 мянган төгрөг, нийт зарлагыг 5,878,311.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 3,991,029.5 мянган төгрөгөөр бууруулж 1,887,281.7 мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд: Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 218,888.4 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 29,550.0 мянга, байр ашиглалттай холбоотой зардлыг 6,000.0 мянга, урсгал засвар 2,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, эд хогшил, урсгал засварын зардлыг 135,856.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 4,111,611.3 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны төсөвт тодотгол хийж зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,342,973.7 мянган төгрөг болгож төсвийг 544,308.0 мянган төгрөгөөр бууруулан тодотгожээ. Үүнд, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллыг зардлыг 476,954.9 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 65,698.7 мянга, хангамж, бараа материалын зардлыг 1,654.4 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг 1,342,973.7 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн санхүүжилт 1,342,973.7 мянга, тендерийн орлого 472.5 мянга, нийт 1,343,446.2 мянган төгрөгийн зардал санхүүжүүлэх эх

үүсвэрийг бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд 1,206,847.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 136,598.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,206,847.4 мянган төгрөг буюу 89,9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 68,428.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 5,719.5 мянга, хангамж, бараа материалын зардлаас 8,742.9 мянга, эд хогшил худалдан авах зардлыг 319.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 14,214.5 мянга, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 38,701.4 мянга, үндсэн үйл ажиллагааны төлөвлөөгүй 472.5 мянган төгрөгөөр орлогыг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,301,872.3	1,204,447.4	97,424.9	92,5%
2	Ажил олгогчоос олгох дэмжлэг	41,101.40	2,400.00	38,701.4	5,8%
	дүн	1,342,973.7	1,206,847.4	136,126.3	89,9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд Хотын стандарт хяналтын газар нь нэмэлт санхүүжилт аваагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хотын стандарт хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ И баримтыг бүрэн шивүүлж байх, байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрийн дотоодын хотын стандартын төсөл болон судалгааны ажлыг хэрхэн бүртгэх талаар тодорхой заалт оруулах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг НТАГ-ын Санхүү-нийцлийн хэлтсийн ахлах аудитор Н.Баттогоо, аудитор Ж.Мөнхтуяа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Хотын стандарт хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг НТАГ-т 2023 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 01/47 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 947,273.7 мянган төгрөгөөс 2 хувь буюу 18,945.5 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувь буюу 15,156.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор орлогч даргын орон тоог хассанаас 9,785.3 мянган төгрөгийн цалингийн зардал, байгууллагын үйл ажиллагааг цахимд шилжүүлснээр 241.3 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал, 466.0 мянган төгрөгийн тээвэр шатахууны зардал, 14,214.37 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлын хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад тайлант онд нийт 2,931,382.4 мянган төгрөгийн 104 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас тайлант оны 386,226.4 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3. “тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх” заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол улсын Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг шалгахад зөрчил илэрсэнгүй Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар зөрчил илрээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 115,562.6 мянган төгрөгийн 4 зөвлөмж, 5,261.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	5,261.3	2	5,261.3	100%
Зөвлөмж	4	115,562.6	4	115,562.6	100%
Нийт дүн	6	120,823.9	6	120,823.9	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гаргаагүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 190,247.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс, аудитын явцад 190,247.6 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд өмнөх оны 190,247.6 мянган төгрөгийн үеийн үр дүнг илэрхийлээгүй

Аудитаар нийт 270.0 мянган төгрөгийн зөрчилд² 2 зөвлөмж өгсөн.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ 270.0 мянган төгрөгийн И баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2. "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6. "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй", нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2, 17.6 дах заалтуудыг мөрдөж ажиллах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрийн дотоодын хотын стандартын төсөл болон судалгааны ажлыг хэрхэн бүртгэх талаар тусгасан тодорхой заалтгүй байна. Энэ нь УСНББОУС-31 Биет бус хөрөнгө 51-д "Хэрэв байгууллага нь биет бус хөрөнгийг үүсгэн бий болгох өөрийн дотоодын төслийн судалгааны үе шатыг хөгжүүлэлтийн үе шатнаас ялган зааглаж чадахгүй бол уг байгууллага нь тухайн төслийн зарлагыг зөвхөн судалгааны үе шатанд гарсан мэтээр авч үзнэ", нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрийн дотоодын хотын стандартын төсөл болон судалгааны ажлыг хэрхэн бүртгэх талаар тодорхой тусгах.

3. Авто тээврийн хэрэгсэл дансанд "Хьюндай старекс" маркийн тээврийн хэрэгсэлд тод дэвсгэр бүхий улсын дугаар хэрэглээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4."Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4. дах заалтыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд данснаас хассан хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу илэрхийлсэн	1	190,247.6	1	190,247.6			1	190,247.6				
Дүн	1	190,247.6					1	190,247.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ И баримтыг шивүүлж аваагүй.	1	270.0					1	270.0				
Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрийн дотоодын хотын стандартын төсөл болон судалгааны ажлыг хэрхэн бүртгэх талаар тусгасан тодорхой заалтгүй байна.	1						1					
Авто тээврийн хэрэгсэл дансанд "Хьюндай старекс" маркийн тээврийн хэрэгсэлд тод дэвсгэр бүхий улсын дугаар хэрэглээгүй байна.	1						1					
Дүн	3	270.0					3	270.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд хөрөнгө зарцуулахтай холбоотой 1 тушаал 200.0 мянга, худалдан авалттай холбоотой 10.248.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг тус тус байршуулаагүй.	1	386,226.4					1	386,226.4
Дүн	1	386,226.4					1	386,226.4